



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/483

Булган сум

Тусгай зөвшөөрлийн тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 3 дугаар бүлгийн 3.2 дахь зүйлийн 1.1, 8 дугаар бүлгийн 8.1 дэх зүйлийн 12.13, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 40 дүгээр зүйлийн 40.7, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2.1, 35.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг сунгах цэгийн нэрсийг 1 дүгээр, нэр солих цэгийн нэрийг 2 дугаар хавсралтаар баталж, "Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль"-ийн 15.7-д заасны дагуу тусгай зөвшөөрлийн тоог батлах хүртэлх хугацаагаар сунгасугай.

2.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасны дагуу "Согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөл" сунгахад хураах тэмдэгтийн хураамжийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхийг сумын Засаг дарга нар, Татварын хэлтэс (Д.Лхагвасүрэн), Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Давааням)-т тус тус үүрэг болгосугай.

3.Дээрх цэгүүдийн үйл ажиллагаанд холбогдох хууль, журам, стандартуудын хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллахыг бүх шатны Засаг дарга, аймгийн Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Л.Ганбаатар), Татварын хэлтэс (Д.Лхагвасүрэн), аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2023 оны
06 дугаар сарын 13-ны өдрийн А/А2 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт



**СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ ЦЭГИЙН НЭРС**

д/д	Сумын нэр	Аж ахуйн нэгжийн нэр	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн овог, нэр	Үйлчилгээний төрөл	Бар, ресторан, дэлгүүрийн нэр	Тохирлын үнэлгээний шаардлага хангасан эсэх
1	Тэшиг	"Их илэнхэн" ХХК	Х.Сайханчулуун	Хүнсний дэлгүүр	"Жаргалант"	Тийм
Нийт- 1						

Аймгийн Засаг даргын 2023 оны
06 дугаар сарын 13-ны өдрийн 1/48 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт

**СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН НЭР СОЛИХ ЦЭГИЙН НЭРС**

д/д	Сумын нэр	Тусгай зөвшөөрөл эзэмшигч		Үйлчилгээний төрөл	Худалдаа үйлчилгээний цэгийн нэр	Шинээр тусгай зөвшөөрөл эзэмших		Үйлчилгээний газрын нэр, төрөл
		Аж ахуйн нэгжийн нэр	Захирлын овог, нэр			Аж ахуйн нэгжийн нэр	Захирлын овог, нэр	
1	Булган	"Дэлгэрэх Уран тогоо" ХХК	Г.Энхтайван	Хүнсний дэлгүүр	"Дэлгэрэх"	"Дүүрэн гарьд" ХХК	Д.Батсүх	"Дэлгэрэх" хүнсний дэлгүүр
	Нийт- 1							